

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/23/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч: Я.Самбууням Утас:261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn</p> <p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Амарсанаа Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнхтуул Утас: 261628 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА Б.БАТДАВАА
ТАНАА

2025.04.25 № 1603
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Үндэсний статистикийн хороо үндсэн үйл ажиллагааны хүрээнд нийт төсвийн 66.0 хувь буюу 14,058.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд Статистик мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэхээс гадна хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр тархаахад анхаарч ажилласан байна.

Тайлант онд 2023 оны жилийн эмхэтгэл, сарын мэдээний эмхэтгэл 12, тооллого түүвэр судалгааны үр дүн 44, видео контент 17, зурагт хуудас 224 тус тус бэлтгэж, тархааснаар цахим хуудасны хандалт 1.0 сая, фэйсбүүк хуудасны хандалт 540.0 мянга болж өсжээ.

Төрийн мета өгөгдлийн нэгдсэн санг хөгжүүлж, төрийн 18 байгууллагын 45 өгөгдлийн сангийн 453 хүснэгт, 7082 үзүүлэлтийн мета өгөгдөл, "Төрийн нэгдсэн өгөгдлийн сан"-г шинээр байгуулж, 9 байгууллагын 12 мэдээллийг нэгтгэсэн байна.

Америк, Ази, Номхон далайн орнуудын үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Статистикийн газартай хамтран Хүн амын тооллогын олон улсын 32 дугаар бага хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулсан бөгөөд Статистикийн чанарын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор үйлдвэрлэгчийн 13 чанарын тайланг боловсруулжээ.

Үндсэн чиг үүрэг болох албан ёсны статистик мэдээ боловсруулахад нийт 5 төрлийн 48 бүлэг, 346 үзүүлэлт мэдээ, тооллого, түүвэр судалгааг нэгтгэн боловсруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд 2,995.4 сая төгрөг, хагас жилийн мал тооллогод 682.0 сая төгрөг, байр ашиглалтын үйлчилгээнд 701.1 сая төгрөг, хүн амын тооллогод 626.1 сая төгрөг, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 394.8 сая төгрөг, малын ашиг шимийн судалгаанд 203.0 сая төгрөг, холбооны суваг ашигласны хөлс, мал, тэжээвэр амьтдын тооллого, аж үйлдвэрийн салбарын үнийн судалгаа болон бусад 11 төрлийн тооллого, судалгаанд 964.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудаа нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байгаа боловч төсвийг үндэслэлтэй судалгаанд тулгуурлан бодитой төлөвлөдөггүйгээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1,886.5 сая төгрөгөөр баталж, 1,738.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Бусад асуудал

Тайлант онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Мянганы сорилын сан, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан, Хүүхдийн сан зэрэг байгууллагатай хамтран 12 төслийг хэрэгжүүлж, нийт 603.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 485.5 сая төгрөгийг зарцуулж, 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	778,541.6	951,846.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,832.6	21,570.6
33	АВЛАГА	157,131.2	125,596.9
34	УРЬДЧИЛГАА	157,149.2	362,091.2
35	БАРАА МАТЕРИАЛ	435,428.5	442,587.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,224,467.3	3,236,909.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,224,467.3	3,236,909.5
39200	Биет хөрөнгө	4,099,638.8	3,164,203.2
39300	Биет бус хөрөнгө	124,828.4	72,706.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,003,008.8	4,188,755.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,075.1	1,973.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,075.1	1,973.7
41300	Өглөг	1,075.1	1,973.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,001,933.8	4,186,781.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,001,933.8	4,186,781.9
51200	Хуримтлагдсан үр дүн	4,998,800.4	4,183,648.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,133.4	3,133.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,003,008.8	4,188,755.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24,047,754.6	23,602,266.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	451,186.2	467,556.9
120	Нийтлэг татварын бус орлого	451,186.2	467,556.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,596,568.4	23,134,709.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,071,357.6	24,396,100.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,071,357.6	24,396,100.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,752,999.6	22,977,820.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,781,207.8	12,961,503.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,245,602.1	1,614,057.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	761,262.8	700,968.1
2105	Нормативт зардал	887.7	9,131.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,386.2	126,693.9
2107	Томилолт, зочны зардал	314,914.0	546,757.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,068,644.8	5,145,826.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,516,094.2	1,872,881.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,318,358.0	1,418,280.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,023,603.0)	(793,834.1)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	96,922.0	15,783.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,120,525.1)	(809,617.1)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,122,458.8	-	6,122,458.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,710.8	-	2,710.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,125,169.6	-	6,125,169.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,710.8)	-	(2,710.8)
9	Тайлант үеийн үр дүн	(1,120,525.1)	-	(1,120,525.1)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,001,933.8	-	5,001,933.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(5,534.8)	-	(5,534.8)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,996,399.0	-	4,996,399.0
19	Тайлант үеийн үр дүн	(809,617.1)	-	(809,617.1)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,186,781.9	-	4,186,781.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	28,268,790.2	23,298,998.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,142.6	8,822.0
120	Нийтлэг татварын бус орлого	12,142.6	8,822.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,256,647.6	23,290,176.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,250,052.8	23,281,290.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,250,052.8	23,281,290.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,769,562.0	21,743,661.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,696,607.1	12,382,877.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,235,603.2	1,610,447.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	537,389.0	502,929.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,786.0	164,957.4
2107	Томилолт, зочны зардал	283,711.6	548,719.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,674,071.2	6,099,845.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,246,393.9	433,884.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,480,490.8	1,537,629.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,737.4	17,708.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,755.6	24,970.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,755.6	24,970.0
2200	Дотоод эх үүсвэрээр	20,755.6	24,970.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,755.6)	(24,970.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,018.3)	(7,262.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,850.9	28,832.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,832.6	21,570.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,784,499,500.00	21,393,578,570.04	(390,920,929.96)	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,784,499,500.00	21,393,578,570.04	(390,920,929.96)	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,814,604,000.00	20,471,108,419.71	(343,495,580.29)	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,509,176,500.00	11,338,820,056.50	(170,356,443.50)	98.5
210101	Үндсэн цалин	6,112,712,700.00	6,239,630,850.98	126,918,150.98	102.1
210102	Нэмэгдэл	3,480,473,300.00	3,048,463,986.71	(432,009,313.29)	87.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,118,609,700.00	1,108,312,937.87	(10,296,762.13)	99.1
210104	Урамшуулал	797,380,800.00	916,362,538.65	118,981,738.65	114.9
210105	Гэрээт ажлын хөлс	-	26,049,742.29	26,049,742.29	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	1,439,510,100.00	1,420,064,098.46	(19,446,001.54)	98.6
210201	Тэтгэврийн даатгал	979,032,000.00	967,971,347.33	(11,060,652.67)	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	115,119,200.00	114,274,165.69	(845,034.31)	99.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	57,747,700.00	56,849,134.77	(898,565.23)	98.4
210204	Ажилгүйдлийн даатгал	57,372,000.00	55,984,269.64	(1,387,730.36)	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	230,239,200.00	224,985,181.03	(5,254,018.97)	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	176,852,500.00	172,202,594.96	(4,649,905.04)	97.4
210401	Бичиг хэрэг	45,727,400.00	46,373,299.00	645,899.00	101.4
210402	Тээвэр, шатахуун	50,920,500.00	50,386,700.00	(533,800.00)	99.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,644,600.00	44,512,488.96	(4,132,111.04)	91.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,560,000.00	30,930,107.00	(629,893.00)	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	177,850,700.00	177,302,027.00	(548,673.00)	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,500,000.00	15,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	162,350,700.00	161,802,027.00	(548,673.00)	99.7
2107	Томилолт, зочны зардал	70,620,000.00	69,789,171.00	(830,829.00)	98.8
210702	Дотоод албан томилолт	70,620,000.00	69,789,171.00	(830,829.00)	98.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,331,873,900.00	7,187,105,118.79	(144,768,781.21)	98.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,523,871,300.00	6,407,964,458.56	(115,906,841.44)	98.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,253,000.00	2,961,000.00	(292,000.00)	91.0
210803	Даатгалын үйлчилгээ	30,473,800.00	26,711,180.00	(3,762,620.00)	87.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,110,700.00	1,969,692.00	(1,141,008.00)	63.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	516,000.00	429,000.00	(87,000.00)	83.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	604,762,000.00	581,711,288.23	(23,050,711.77)	96.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	165,887,100.00	165,358,500.00	(528,600.00)	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,720,300.00	105,825,353.00	(2,894,947.00)	97.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,273,100.00	43,919,160.00	(1,353,940.00)	97.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,447,200.00	61,906,193.00	(1,541,007.00)	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	969,895,500.00	922,470,150.33	(47,425,349.67)	95.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	39,225,800.00	35,433,200.00	(3,792,600.00)	90.3
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	39,225,800.00	35,433,200.00	(3,792,600.00)	90.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	930,669,700.00	887,036,950.33	(43,632,749.67)	95.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,050,000.00	49,050,000.00	-	100.0

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	168,800,300.00	136,760,028.33	(32,040,271.67)	81.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	649,997,400.00	638,945,157.00	(11,052,243.00)	98.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,822,000.00	62,281,765.00	(540,235.00)	99.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,784,499,500.00	21,388,672,492.27	(395,827,007.73)	98.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,784,499,500.00	21,388,672,492.27	(395,827,007.73)	98.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	21,784,499,500.00	21,388,672,492.27	(395,827,007.73)	98.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,906,077.77	4,906,077.77	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	320	320	-	100.0
620001	Удирдах ажилтан	36	36	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	271	271	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13	13	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	320	320	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	162	162	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	116	116	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	39	39	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,870,998,205.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,870,998,205.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,651,674,535.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,044,057,558.56
210101	Үндсэн цалин		463,728,053.09
210102	Нэмэгдэл		271,935,275.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт		17,246,000.00
210104	Урамшуулал		20,186,585.00
210105	Гэрээт ажлын хөлс		270,961,644.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		190,383,462.35
210201	Тэтгэврийн даатгал		156,670,323.13
210202	Тэтгэмжийн даатгал		10,304,931.06
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,152,462.94
210204	Ажилгүйдлийн даатгал		1,563,685.69
210205	Эрүүл мэндийн даатгал		19,692,059.53
2104	Хангамж, бараа материалын зардал		330,727,330.29
210401	Бичиг хэрэг		20,602,970.00
210402	Тээвэр, шатахуун		264,840,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		44,688,590.29
210404	Ном, хэвлэл		95,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,984,740.00
210602	Тавилга		4,984,740.00
2107	Томилолт, зочны зардал		478,930,048.00
210701	Гадаад албан томилолт		76,949,908.00
210702	Дотоод албан томилолт		401,980,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,270,267,947.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,250,037,426.86
210803	Даатгалын үйлчилгээ		224,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		147,741.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		19,836,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		332,323,448.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		198,459,258.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		133,864,190.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		219,323,670.33
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,580,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,580,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		207,743,670.33
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		207,743,670.33
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,870,998,205.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,870,998,205.39
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		448,201,847.23
131103	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		831,779,800.87
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,383,348,389.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		207,668,167.59

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 472.1 сая төгрөгийн 30 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 114.7 сая төгрөгийн 20 зөрчил² илэрснээс 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 67.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 47.6 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 114.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 13 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 10 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан 13 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 114.7 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 67.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 47.6 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

5.2 Аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байгууллагууд

Албан шаардлага:

Илрүүлэлт 1. Нэр бүхий 2 иргэнтэй судалгаа хийлгэх ажлын гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд үндэслэн төлбөрийг олгох гэрээний заалтыг зөрчин ажлын хөлсийг 100.0 хувь олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т “Хугацааг ямар нэгэн үүрэг гүйцэтгэхийн тулд тогтоосон бөгөөд хэлцэлд өөрөөр заагаагүй бол хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор уг үүргийг гүйцэтгэсэн байна”, 206 дугаар зүйлийн үүрэг гүйцэтгэх зарчим 206.1-т “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-т “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, ҮСХ-2/81, ҮСХ-2/80 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний 3.2-т “Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар захиалагч нь урьдчилгаа төлбөр болох ажлын хөлсний 40 хувийг шилжүүлж, гэрээнд заасны дагуу гүйцэтгүүлсэн ажлыг хүлээн авч үлдсэн 60 хувийг ажлын 7 хоногийн дотор ажил гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний гэрээг хууль эрх зүйн дагуу байгуулж, гэрээний үүргийн биелэлт хэрэгжилтийг хангуулж, ажлын гүйцэтгэл үр дүнг үндэслэн гэрээт ажлын хөлсийг олгоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант онд нийт 39.3 сая төгрөгийн үнийн дүнтэй бараа материалын төсөвт өртгийг хувааж, 1 аж ахуй нэгж, байгууллагатай 3 шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 24.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өөрөө санхүүжүүлснээс бусад хэлбэрээр төрийн болон орон нутгийн өмч бий болгох, худалдан авах, хуулийн этгээд үүсгэн байгуулах зардал, хувь оролцоо, дүрмийн санд оруулсан хөрөнгө, түүнтэй холбогдсон бүх төрлийн санхүүгийн хэрэгсэл нь тухайн шатны төсвийн зарлага байна”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж, бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3.1 Зөвлөмж

Илрүүлэлт 1. Тайлант онд цаг ашиглалт, нийгмийн үзүүлэлт, хүн ам өрхийн мэдээллийн сангийн судалгаа, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах зэрэг үндсэн чиг үүргийн ажлыг хийлгэхээр гэрээт ажилтан ажиллуулж, нийт 35.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын болон албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүрэгтэй адил арга хэмжээг бусдаар гүйцэтгүүлж үргүй зардал гаргахгүй байх, байгууллагын хүний нөөц, дотоод эх үүсвэрийг ашиглан чанартай гүйцэтгэж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 472.1 сая төгрөгийн 30 алдаа³ илэрснийг аудитын явцад залруулсан.

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт дүн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндэсний статистикийн хороо	1	88.4	1	88.4				
2	Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс	1	0.8	1	0.8				
		1	5.7	1	5.7				
3	Булган аймгийн Статистикийн хэлтэс	1	2.4	1	2.4				
		1	22.3	1	22.3				
		1	15.9	1	15.9				
4	Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтэс	1	4.5	1	4.5				
		1	3.1	1	3.1				
		1	1.5	1	1.5				
		1	0.1	1	0.1				
		1	0.3	1	0.3				
5	Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс	1	1.0	1	1.0				
		1	0.1	1	0.1				
		1	290.7	1	290.7				
		1	-	1	-				
6	Дорнод аймгийн Статистикийн хэлтэс	1	3.4	1	3.4				
7	Дундговь аймгийн Статистикийн хэлтэс	1	0.1	1	0.1				
		1	-	1	-				
		1	0.1	1	0.1				
8	Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс	1	5.5	1	5.5				
9	Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	4.3	1	4.3				
10	Ховд аймгийн Статистикийн хэлтэс	1	16.7	1	16.7				
11	Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс	1	0.3	1	0.3				
		1	0.1	1	0.1				
		1	0.1	1	0.1				
12	Нийслэлийн статистикийн газар	1	0.2	1	0.2				
		1	1.3	1	1.3				
		1	0.6	1	0.6				
		1	2.0	1	2.0				
		1	0.9	1	0.9				

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

НИЙТ	30	472.1	30	472.1			
-------------	-----------	--------------	-----------	--------------	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 114.7 сая төгрөгийн 20 зөрчил⁴ илэрснээс 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 67.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 47.6 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндэсний статистикийн хороо	1	35.6				-	1	35.6
	1	22.1			1	22.1		-
	1	39.3			1	39.3		-
Булган аймгийн Статистикийн хэлтэс	1	3.7		-		-	1	3.7
Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтэс	1	3.6				-	1	3.6
Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс	1	0.1	1	0.1		-		-
Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс	1	0.5	-	-	-	-	1	0.5
Орхон аймгийн Статистикийн хэлтэс	1	1.9		-	1	1.9		-
Орхон аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Орхон аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	0.6				-	1	0.6
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	0.1				-	1	0.1
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	2.2	-	-	1	2.2	-	-
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	0.3				-	1	0.3
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Ховд аймгийн Статистикийн хэлтэс	1	3.2				-	1	3.2
Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-
Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс	1	1.5	-	-	1	1.5		-
НИЙТ	20	114.7	1	0.1	5	67.0	14	47.6

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

4.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх, тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 416.1 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 407.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 8.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндэсний статистикийн хороо ТЕЗ	1	404.8			1	404.8				
Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-		
Төв аймгийн Статистикийн хэлтэс	1	-					1	-		
Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс	1	3.0			1	3.0				
Нийслэлийн Статистикийн газар	1	-				-	1			
	1	8.3				-	1	8.3		
НИЙТ	6	416.1		-	2	407.8	4	8.3		